

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас тус тус баталсан холбогдох журмууд болон “Сүү” ХК-ийн Дүрмийг тус тус удирдлага болгон явууллаа.

Хурлын цаг: 15:00-17:30,

Хурлын байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын байранд,

Хурлын дарга: Ц.Соёл-Эрдэнэ,

Хурлын нарийн бичгийн дарга: Б.Цэрэндорж,

Хурлын ирц: Саналын эрх бүхий 323,817,802 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 94,13%,

Хуралд урилгаар оролцсон хүмүүс:

- “Сүү” ХК-ийн Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал С.Энхтуяа, Маркетинг, борлуулалт хариуцсан дэд захирал М.Болод, Санхүүгийн албаны дарга А.Цагаансар, Санхүүгийн шинжээч, эдийн засагч Б.Отгонбаатар,

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал,
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал,
4. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал,
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал,
4. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,

Танилцуулсан нь:

Нарийн бичгийн дарга:

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. “Сүү” ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна.

Та бүхэнд ээлжит хурлын ирцийн мэдээг танилцуулъя.

“Сүү” ХК-ийн саналын эрх бүхий нийт 344,000,000 ширхэг хувьцааны 94,13% болох нийт 323,817,802 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид хуралд хүрэлцэн ирсэн байгаа бөгөөд Монгол Улсын Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн байх тул хурлын ирц бүрдсэн байна.

Та бүхэнд “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 03-р сарын 14-ний өдрийн № 04 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” тогтоолын дагуу батлагдсан хуралдааны дэгийг танилцуулъя.

Хуралдааны дэгийг танилцуулав.

Хурлыг нээж ХЭХурлын дарга, “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Ц.Соёл-Эрдэнэ үг хэлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг баталсны дагуу бид энэ удаагийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж батлах ёстой байгаа. Үүнд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал,
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал,
4. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудлууд байгаа.

Хурлийн үйл ажиллагаанд амжилт хүсье.

Иймд хэлэлцэх эхний асуудлын дагуу Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Гүйцэтгэх захирал Б.Гантулга танилцуулах байгаа. Танилцуулга хийсний дараагаар та бүхэн хэлэлцэх асуудалтай холбоотой асуух зүйлс байвал асууж болно.

- “Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийн талаар танилцуулга хийв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйлс байна уу?

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Б.Ичинхорлоо: Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа сууж байгаа бүх хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл гишүүд, удирдлагуудад баяр хүргэмээр байна. Миний хувьд “Сүү” ХК-ийн хуралд 2 дахь удаагаа сууж байна. Хувьцаа эзэмшигчдэд 2017 оны цэвэр ашгаас ногдол ашиг хүртээхээр болсон гэж ярилаа. Үүнийг хэрхэн тарааж байгаа вэ? Мөн 2016 оны ногдол ашгийг хэрхэн тараасан бэ?

Хариулт:

Санхүүгийн шинжээч, эдийн засагч Б.Отгонбаатар: 2016 оны ногдол ашгийг 2017 оны 09 дүгээр сараас эхлэн 12 дугаар сарын хооронд ҮЦТТХТ-өөр дамжуулан нэгж хувьцаанд татвар суутгагдсан дүнгээр 9 төгрөг тараасан. 2017 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд

татвар суутгагдсан дүнгээр 3 төгрөгийг 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээрх дансаар дамжуулан олгох байгаа.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч С.Халиун: “Сүү бонд”-ыг IFC байгууллагаас авсан зээлээ төлөхөд зарцуулсан, мөн PET савлагаанд хөрөнгө оруулсан гэж тайланд дурдлаа. Энэхүү бондын зарцуулалтын тайланг гаргах, дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжтой юу?

Хариулт:

“Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга: “Сүү бонд” нийт 6 тэрбум төгрөгийн хөрөнгө босгосон. Үүний 4,5 тэрбум төгрөг IFC буюу Олон улсын санхүүгийн корпорацийн зээлийг төлөхөд зарцуулагдаж, 1,5 тэрбум төгрөг нь PET савлагааны тоног төхөөрөмжийг худалдаж авахад зарцуулагдсан байгаа. PET савлагааны тоног төхөөрөмжийн гэрээ хийгдсэн, захиалагдсан байгаа. Бид энэ ондоо багтааж PET савлагаатай шинэ бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах зорилт тавин ажиллаж байна. Холбогдох тайланг Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн байгаа.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч С.Халиун: “Сүү бонд”-ын эргэн төлөлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч.

Хариулт:

“Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга: “Сүү бонд”-ын эргэн төлөлтийг гүйцэтгэх 3 хувилбар байгаа. Нэг дэх хувилбар бол дотоодын арилжааны банктai тохиролцоонд хүрсэн байгаа ба зээлрүү хөрвүүлээд төлөх боломжтой. Хоёр дахь хувилбар бол ахин бонд гаргах боломжтой байгаа, харин гурав дахь хувилбар бол нэмж хувьцаа гарган бондын эргэн төлөлтийг гүйцэтгэх боломжтой байгаа. “Сүү бонд” хугацаандаа төлөгдөнө, бүх шийдлүүд гарсан байгаа.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Н.Дуламжав: “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд баярлалаа. Маш сайн хурал зохион байгуулж байна. Намайг 2 жилийн өмнө хуралд сууж байхад Япон улс уруу цөцгийн тос нийлүүлэх төсөл яригдаж байсан, тэр төслийн талаар мэдээлэл өгнө үү. Мөн цөцгийн тосны амт өөрчлөгдсөн байсан, технологийн хувьд өөрчлөлт орсон уу?

“Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга: Япон улс уруу экспортод бүтээгдэхүүн гаргах тухай асуулаа. Түүхий эдийн нөөцийн асуудалтай холбоотойгоор манай компанийн цөцгийн тосны үйлдвэрлэл өнөөдрийн байдлаар дотоодын эрэлтээ хангаж чадахгүй байгаа. Уг төсөл 2012 оноос эхэлсэн, 2015 онд экспортод гаргахаар зорьж ажиллаж байсан боловч өдийг болтол гадагшаа гаргах хэмжээний цөцгийн тос үйлдвэрлэх боломжгүй байгаа учраас тэр төсөл маань хойшлогдоод явж байгаа. Тухайн үед харилцаж байсан компанитайгаа бол харилцаатай байгаа.

“Сүү” ХК-ийн Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал С.Энхтуяа: Цөцгийн тосны нөөцөө бид 3 газар бэлтгэдэг байгаа. Өөрөөр хэлбэл “Сүү” ХК-ийн төв үйлдвэр дээр, мөн Орхон аймгийн Эрдэнэт хот дахь болон Хэнтий аймгийн Батширээт сум дахь салбар үйлдвэрүүд дээрээ нөөцөө бэлтгэж байгаа. Иймд өөр өөр газраас түүхий эдээ татан авдаг учраас тухайн бүс нутагт ургаж байгаа ургамалтай холбоотойгоор амтны хувьд өөр байсан байж болно. Мөн түүхий эд зуншлага ямар байснаас маш их шалтгаалдаг байгаа. Өнгөрсөн

жил зуншлага муу байсан учир амт өөрчлөгдсөн байж болно. Гэхдээ технологийн хувьд ямар нэгэн өөрчлөлт ороогүй.

Хувьцаа эзэмшигч Б.Алтанцэцэг: Би Хэнтий аймгийн Батширээт суманд байхад цөцгийн тос үнэхээр олдохгүй байсан. Маш гоё цөцгийн тостой. Цөцгийн тосны технологи сайн, цаашлаад экспортод гаргах гэж байгаад баяртай байна. Ингэснээр бидэнд ирэх ногдол ашиг нэмэгдэх үндэс болно гэж үзэж байгаа. Сая ажилчид, бэлтгэн нийлүүлэгчиддээ хувьцаа эзэмшүүлэх талаар танилцууллаа. Хувьцаа авах сонирхолгүй хүнд хувьцаа өгөх үү? Мөн гүйцэтгэх захирал та компанид хэдэн хувийн хувьцаа эзэмшдэг вэ?

“Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга: За, сүүлийн асуултын хувьд миний хувийн мэдээлэл учир хариулах боломжгүй байна. Ажилчид, бэлтгэн нийлүүлэгчиддээ хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хувьд малчид, фермерүүдийн зүгээс хувьцаа эзэмших хүсэлт маш их ирдэг. Тиймээс зөвхөн өөрсдийнх нь хүсэлтийн дагуу, хувьцаа эзэмших сонирхолтой хүмүүст бид хувьцаа эзэмшүүлнэ гэж төлөвлөж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Нарийн бичгийн дарга: Дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудал “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг СЗХ-ны 2011.12.07-ны өдрийн №367 тоот тогтоолоор батлагдсан Санал хураах кумулятив аргыг хэрэглэн сонгох тухай асуудал байгаа.

Та бүхэнд өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа буюу бүрэн эрх нь дуусгавар болж байгаа ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Б.Түвшинтөгс
4. Д.Жамъян
5. Д.Уянгалянхуа
6. Ц.Соёл-Эрдэнэ
7. Б.Гантулга
8. Н.Бадамханд

Хараат бус гишүүнээр:

1. Н.Цэрэндорж
2. Ш.Даваалимбэ
3. Г.Баяр
4. П.Мэндсайхан

Та бүхэнд “Сүү” ХК-ийн ТУЗ-д нэр дэвшиж буй гишүүдийг танилцуулъя.

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Б.Түвшинтөгс
4. Д.Жамъян
5. Д.Уянгалянхуа
6. Ц.Соёл-Эрдэнэ
7. Д.Тунгалаг

8. Ш.Батжаргал

Хараат бус гишүүнээр:

5. Н.Цэрэндорж
6. Ш.Даваалимбэ
7. Г.Баяр
8. П.Мэндсайхан

ТУЗ-д нэр дэвшиж буй гишүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг дэлгэцээр танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Нарийн бичгийн дарга: Хурлын дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудал “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал байгаа.

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай санал гаргасан байгааг та бүхэнд танилцуулъя. Үүнд:

“Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг дараах байдлаар тогтоож, 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, улирал тутамд 1 удаа тооцон олгох саналыг гаргаж байна. Үүнд:

№	Албан тушаал	Улирал тутамд олгох цалин, урамшууллын хэмжээ /Төгрөг/
1.	ТУЗ-ийн дарга	5,000,000 /Таван сая/
2.	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн	1,000,000 /Нэг сая/

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Нарийн бичгийн дарга: Хурлын дэгийн дагуу Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэнэ.

- “Сүү” ХК-ийн 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан болон 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай асуудлаар дэлгэцээр танилцуулга хийв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Нарийн бичгийн дарга: Одоо дэгийн дагуу хурал завсарлана. Үүний дараагаар тооллогын комисс тогтоол танилцуулна.

Хувьцаа эзэмшигчдэд саналын хуудасны загварыг танилцуулж, бөглөх зааварчилгааг өгөөд хурал завсарлав.

"Сүү" ХХ-ийн ТУЗ-ийн
2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн
№04 тоот Тогтоолын хавсралт №4

**"Сүү" ХХ-ийн "Хувьцаа эзэмшигчдийн
ЭЗЛЖИТ ХУРАЛ"-Д САНАЛ АВАХ ХУУДАС**
(Халалцах асуудал №1/)

Энэхүү санал авах хуудсаар 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, "Халидай Инг" зочид буудлын байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр.

Регистрийн дугаар:

Санал өгөх хувьцааны тоо:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн,

№	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан
1.	Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал.		

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Тө санал авах хуудсыг бөтөхдөө өөрийн сонгох буй хэсэгт "Зөвөл" + тэмдэглэгээг хийнэ үү.
2. Санал авах хуудсыг засварласан, бэлтгэсэн тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд өөрийн хөрөнгийн үнэт цаасны компанийн /ЦК/ дээр очиж хурлын материалтай танилцж, санал авах хуудсаар саналдаа өгнө.
4. Хэрэв өөр хэнээс төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотархатаар гарчиглуулсан байна.

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: /Гарын үсэг/

Брокер /ЦК-аар дамжуулан санал өгсөн бол: /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 2018 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолоон:

Тооллогын комиссын дарга: /Б.Доржбат/

Санал авах хуудсыг хүчингүйд тооцон бол шалтгаан:

-----000-----

"Сүү" ХХ-ийн ТУЗ-ийн
2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн
№04 тоот Тогтоолын хавсралт №4

**"Сүү" ХХ-ийн "Хувьцаа эзэмшигчдийн
ЭЗЛЖИТ ХУРАЛ"-Д САНАЛ АВАХ ХУУДАС**
(Халалцах асуудал №2-2/)

Энэхүү санал авах хуудсаар 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, "Халидай Инг" зочид буудлын байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр.

Регистрийн дугаар:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн,

Кумулятив санал хураах аргаар өгөх саналын тоо:



№	"Сүү" ХХ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.	Н.Цэрэндорж	
2.	Ш.Даваалимба	
3.	Г.Баяр	
4.	П.Мэндсайхан	

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Тө санал авах хуудсыг бөтөхдөө өөрийн сонгох буй хэсэгт "Зөвөл" + тэмдэглэгээг хийнэ үү.
2. Санал авах хуудсыг засварласан, бэлтгэсэн тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд өөрийн хөрөнгийн үнэт цаасны компанийн /ЦК/ дээр очиж хурлын материалтай танилцж, санал авах хуудсаар саналдаа өгнө.
4. Хэрэв өөр хэнээс төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотархатаар гарчиглуулсан байна.

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: /Гарын үсэг/

Брокер /ЦК-аар дамжуулан санал өгсөн бол: /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 2018 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолоон:

Тооллогын комиссын дарга: /Б.Доржбат/

Санал авах хуудсыг хүчингүйд тооцон бол шалтгаан:

"Сүү" ХХ-ийн ТУЗ-ийн
2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн
№04 тоот Тогтоолын хавсралт №4

**"Сүү" ХХ-ийн "Хувьцаа эзэмшигчдийн
ЭЗЛЖИТ ХУРАЛ"-Д САНАЛ АВАХ ХУУДАС**
(Халалцах асуудал №2-1/)

Энэхүү санал авах хуудсаар 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, "Халидай Инг" зочид буудлын байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр.

Регистрийн дугаар:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн,

Кумулятив санал хураах аргаар өгөх саналын тоо:

№	"Сүү" ХХ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн эрдийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.	Д.Ганбаатар	
2.	Д.Цэрэнхонгод	
3.	Д.Жамъян	
4.	Б.Түвшинтөгс	
5.	Д.Уянгалхуяа	
6.	Ц.Соёл-Эрдэнэ	
7.	Д.Тунгалаг	
8.	Ш.Батхажрал	

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Тө саналдаа үзэг, эсвэл бэлээр тэмдэглэнэ үү. /Харандаагаар тэмдэглэсэн бол хүчингүйд тооцно/
2. Санал авах хуудсыг засварласан, бэлтгэсэн тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. ТУЗ-ийн гишүүдийн сонгох санал өгөхдөө кумулятив аргаар нэр дэвшигчид өгөх саналын тоо нь идэвч байх болно. Харин нийлбэр дүн нь кумулятив аргаар өгөх саналын нийт тооноос хэтрэх болохгүй. Хэтрэсэн тохиолдолд саналын хуудас хүчингүйд тооцогдоно.
4. Хэрэв өөр хэнээс төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотархатаар гарчиглуулсан байна.

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: /Гарын үсэг/

Брокер /ЦК-аар дамжуулан санал өгсөн бол: /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 2018 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолоон:

Тооллогын комиссын дарга: /Б.Доржбат/

Санал авах хуудсыг хүчингүйд тооцон бол шалтгаан:

"Сүү" ХХ-ийн ТУЗ-ийн
2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн
№04 тоот Тогтоолын хавсралт №4

**"Сүү" ХХ-ийн "Хувьцаа эзэмшигчдийн
ЭЗЛЖИТ ХУРАЛ"-Д САНАЛ АВАХ ХУУДАС**
(Халалцах асуудал №3/)

Энэхүү санал авах хуудсаар 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, "Халидай Инг" зочид буудлын байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр.

Регистрийн дугаар:

Санал өгөх хувьцааны тоо:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн,

№	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан
1.	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал.		

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Тө санал авах хуудсыг бөтөхдөө өөрийн сонгох буй хэсэгт "Зөвөл" + тэмдэглэгээг хийнэ үү.
2. Санал авах хуудсыг засварласан, бэлтгэсэн тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд өөрийн хөрөнгийн үнэт цаасны компанийн /ЦК/ дээр очиж хурлын материалтай танилцж, санал авах хуудсаар саналдаа өгнө.
4. Хэрэв өөр хэнээс төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотархатаар гарчиглуулсан байна.

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: /Гарын үсэг/

Брокер /ЦК-аар дамжуулан санал өгсөн бол: /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 2018 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолоон:

Тооллогын комиссын дарга: /Б.Доржбат/

Санал авах хуудсыг хүчингүйд тооцон бол шалтгаан:

-----000-----

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Тооллогын комисс тогтоол танилцуулна.

Тооллогын комиссын дарга: Тооллогын комисс хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор, саналын хуудсаар авсан саналуудыг нэгтгэж дүнг гаргалаа. Одоо та бүхэнд дүнг танилцуулъя.

“Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар, хэлэлцсэн эхний асуудал болох Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудлаар нийт 323,799,285 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч 2,309 хувьцааны хүчингүй санал гарсан байна.

Эхний хэлэлцсэн асуудал болох “Сүү” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудлыг нийт хувьцаа эзэмшигчдийн 94,13% саналаар дэмжсэн байна.

Дараагийн хэлэлцсэн асуудал болох ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтын дүнг танилцуулъя.

ТУЗ-ийн ердийн гишүүдийг кумулятив аргаар сонгох санал хураалтаар: Нийт 2,590,500,591 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч 9,736 хувьцааны хүчингүй санал,

ТУЗ-ийн хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох санал хураалтаар: Нийт 1,295,217,167 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч 10,464 хувьцааны хүчингүй санал тус тус гарсан байна. Та бүхэнд ТУЗ-ийн гишүүн тус бүрд өгсөн саналын нэгдсэн дүнг танилцуулъя.

№	Тогтоол	Зөвшөөрсөн хувьцааны санал		Татгалзсан хувьцааны санал			
		Тоо	Хувь	Тоо	Хувь		
1.	ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ	Ердийн гишүүнээр:					
		1. Д.Ганбаатар	323,965,790	12,5%	24,890	0,0072%	
		2. Д.Цэрэнжигмэд	323,807,377	12,5%			
		3. Б.Түвшинтөгс	323,776,224	12,5%			
		4. Д.Жамъян	323,782,164	12,5%			
		5. Д.Уянгалянхуа	323,820,369	12,5%			
		6. Ц.Соёл-Эрдэнэ	323,795,830	12,5%			
		7. Д.Тунгалаг	323,788,455	12,5%			
		8. Ш.Батжаргал	323,764,382	12,5%			
		Хараат бус гишүүнээр:					
		1. Н.Цэрэндорж	323,816,039	25%	41,527	0,012%	
		2. Ш.Даваалимбэ	323,797,117	25%			
		3. Г.Баяр	323,806,830	25%			
		4. П.Мэндсайхан	323,797,181	25%			

Гурав дахь хэлэлцсэн асуудал болох ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтаар нийт 323,795,594 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч 15 хувьцааны хүчингүй санал гарсан байна.

ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлыг нийт хувьцаа эзэмшигчдийн 94,13% саналаар дэмжсэн байна.

Хэлэлцсэн асуудлуудаар гарсан Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолуудыг уншиж танилцуулан хурал 17:30 цагт хаасныг мэдэгдэв.

Тусгай тэмдэглэл: Байхгүй.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

/Б.ЦЭРЭНДОРЖ/

Хянасан:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА:

/Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ/